



**ХЭНТИЙ АЙМГИЙН
БОР-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/168

Бор-Өндөр сум

**Газар эзэмших эрхийн гэрчилгээг
өвлүүлэх тухай**

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь хэсэг, Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийн гэрчилгээг өвлөн авах тухай нотлох баримтыг бүрдүүлэн, өргөдөл гаргасан иргэн (Дугарсүрэн овогтой Гэрэлмаа) -д газар эзэмших эрхийн гэрчилгээг Нэгдүгээр хавсралтад зааснаар өвлүүлсүгэй.

2. Газар эзэмших эрхийн гэрчилгээ авсан иргэнтэй хуулийн дагуу анхдагч гэрээний хугацааг дуустал газрыг үргэлжлүүлэн эзэмшүүлж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Т.Эрдэнэзаяа) -д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг газар эзэмших эрхийн гэрчилгээг авсан иргэн (Д.Гэрэлмаа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан Бор-Өндөр хотын Захирагчийн 2011 оны 121 тоот болон 2012 оны 03 тоот Захирамжийн иргэн (Ч.Дугарсүрэн) -д холбогдох хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Х.ГАЛБАДРАХ

Сумын Засаг даргын 2025 оны 07 дугаар сарын 01-ны өдрийн А/168-р захирамжийн нэгдүгээр хавсралт

Газар болон эзэмшигчийн мэдээлэл

д/д	Эрх шилжүүлэн авч буй иргэн, хуулийн этгээдийн нэр	Регистр	Газрын хэмжээ /м ²	Эзэмших хугацаа /жиж/	Газрын байршил хаяг	Нэгж талбарын дугаар	Зориулалт	Өвлүүлж буй иргэн хуулийн этгээдийн нэр, регистр	Эрх шилжүүлэх үндэслэл
1	Да Дамба Дугарсүрэн Гэрэлмаа	СЦ70120502	700	2	3-р баг Бумбат, Хангай-27 гудамж, 2704 тоот	2322002997	Гэр бүлийн хэрэгцээ	Да Дамба Чойн Дугарсүрэн СЦ43121013	Өвлөх эрхийн гэрчилгээ 2025.06.30/0029
2			48	11	2-р баг Холбоо, Төмөрзамчид-2 гудамж, 213а тоот	2322003924	Гараж		Өвлөх эрхийн гэрчилгээ 2025.06.30/0028